



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/299

Номгон

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын “Цэргийн албаны тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах” журмын 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын Баянхонгор аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 1.7-д заасны дагуу Чөлөөлөх дайны 76 жилийн ойг угтан дайнд оролцсон ахмад дайчдын ар гэрт мөнгөн тусламж үзүүлэх, цэргийн штабын даргын албаны өрөөг засварлахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3260000 (Гурван сая хоёр зуун жаран мянга) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оньг 05 дугаар
сарын 11-ний өдрийн А/269/үгээр захирамжийн



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Чөлөөлөх дайны 76 жилийн ойг угтан дайнд оролцсон ахмад дайчдын ар гэрт мөнгөн тусламж үзүүлэх	8 хүн	150 000 төг	1.200.000 төг
2	Албаны өрөөний засвар	1 өрөө	900 000 төг	900 000 төг
3	Албаны өрөөнүүдийн хаалга	3	420 000 төг	1 260 000 төг
Дүн			3 260 000 төг	

_____оОо_____